

**“МОНГОЛ УЛСАД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2024 оны 11-р сарын 15

Говьсүмбэр

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Биелэлт	Гүйцэтгэлийн хувь
0	1	2	3	4
1.	Соён гэгээрүүлэх, сурч боловсрох эрхийг хангах	Соён гэгээрүүлэх, сурч боловсрох эрхийг хүрээнд хэлтсийн хаагчдад сургалт байгуулж орсон байх	<p>2024 оны 10 дугаар сарын 24-ны өдөр Хүний эрхийн Үндэсний комиссын Говьсүмбэр аймаг дахь референт Б.Наранбаатар “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмын үйл ажиллагаа” сэдвээр хэлтсийн албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Сургалтад байгууллагын бүх албан хаагч хамрагдсан.</p>   <p>Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газар болон аймаг орон нутаг, хэлтсээс зохион байгуулсан танхимын 20 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 250 албан хаагчдыг бүрэн хамруулж ажилласан.</p> 	100%

			<p>Албан хаагчдын монгол бичгийн чадварыг дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын монгол хэл, уран зохиолын багшаас төлбөртэйгөөр "Монгол бичгийн дунд шатны 10 удаагийн сургалт болох 20 багц цагийн хичээлд суралцсан. Сургалтад хэлтсийн бүх албан хаагч хамрагдсан болно.</p> 	
2.	Эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах	Эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаар үйл ажиллагаа зохион байгуулсан байх	<p>Албан хаагчдынхаа эрүүл мэндэд анхаарч, аймгийн "Энхбилиг" эмнэлэгээс эрүүл мэндийн үйлчилгээний талаар танилцуулга, мэдээллийг авч албан хаагчдаа 2 удаагийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулан шаардлагатай албан хаагчдыг эрүүл мэндийн даатгалаар өдрийн эмчилгээ болон хэвтэн эмчлүүлэх нөхцөл боломжоор ханган ажилласан.</p>  <p>Хэлтсийн ойр орчмын талбайг 7 хоног тутам цэвэрлэж, байгалийн үзэгдлээс хамааран цаг тухайд нь халтиргаа гулгаанаас сэргийлэх арга хэмжээ авч иргэдийг ая тухтай, эрүүл аюулгүй орчинд үйлчлүүлэх боломжоор ханган ажиллаж байна. Мөн тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэлтсээрээ 125 хайлаас модыг тарьж, усалгаа арчилгааг тухай бүр хийж байна.</p> 	100%

3	<p>Үйл ажиллагааны хүрээнд</p>	<p>Хүний эрхийг хангах хүрээнд тус хэлтсээс улсын бүртгэлийн байгууллагын чиг үүргийн дагуу иргэдэд хүртээмжтэй байдлаар үйл ажиллагааг зохион байгуулсан байх</p>	<p>"Улсын бүртгэлийн дуудлагын үйлчилгээ" буюу хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үйлчилгээний танхимд хүрэлцэн ирэх боломжгүй иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 425-р Нээлттэй хорих ангитай хамтран улирал бүр очиж үйлчилгээ үзүүлдэг бөгөөд 21 хүмүүжигчид иргэний үнэмлэхийг олгож, 2 хүмүүжигчийн гэрлэлтийг баталж хүний эрхийг ханган ажилласан.</p>  <p>Монголын Хуульчдын холбооны Говьсүмбэр аймаг дахь салбар, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүрийн 5 дугаар сарын 01-ны өдөр зохион байгуулдаг "ХУУЛЬЧИЙН ПРО БОНО" өдөрлөгт хэлтсээс 10 албан хаагч оролцож, нийт 12 иргэнд тоон гарын үсэг олгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчилж, зөвлөгөө мэдээллийг өгч ажилл ав.</p> 	100%
---	--------------------------------	--	---	------

Хувийн болон төрийн байгууллагуудын албан хаагчдад улсын бүртгэлийн үйл ажиллагааг таниулах, тэгш хүртээмжтэй түргэн шуурхайгаар хүрч үйлчлэх зорилгоор аймгийн 22 байгууллагад сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 500 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, зөврийн тоног төхөөрөмж ашиглан тоон гарын үсэг олгож ажилласан байна.




Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүсэлтийн дагуу зөврийн тоног төхөөрөмж ашиглан 2 иргэнд гэрээр очиж улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Аймгийн ахмадын хороотой хамтран аймгийн өндөр настнуудад иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн талаар 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 58 ахмадад зөвлөгөө мэдээлэл өгч, зөврийн тоног төхөөрөмж ашиглан 4 ахмадад үйлчилгээг үзүүлсэн. Мөн үйлчилгээний танхимдаа жирэмсэн болон 0-2 насны хүүхэдтэй эхчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дараалал харгалзахгүй үйлчлүүлэх тэмдгийг байршуулан, дараалалгүй үйлчилж байна.



			<p>Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 84 жил, нэгдсэн тогтолцоонд шилжсэний 15 жилийн ой, "Улсын бүртгэлийн ажилтны өдөр"-ийг угтан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/158, А/163 дугаар тушаалаар байгуулагдсан Улсын бүртгэлийн ажилтны өдрийн арга хэмжээг зохион байгуулах "Ажлын хэсэг"-ийн зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхдийн эрхийг хангах зорилгоор байгууллагын албан хаагчдаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй албан хаагчдад, дэмжлэг, туслалцаа үзүүлэхээр "Хүүхдийн төлөө" аяныг зохион байгуулж тус аяны хүрээнд хэлтсийн албан хаагчдаас 170,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p>  <p>2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар нийт 42 өргөдлийг зохих журмын дагуу бүртгэсэн. Үүний 6 өргөдөл нь албан хаагчдаас, 36 өргөдөл нь иргэдээс ирсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сар, улирал бүр холбогдох газарт хүргүүлж, ирсэн өргөдөл, гомдлыг EDOC системд тухай бүр бүртгэж, цахим болон вэб хуудсанд байршуулан ажилласан. 42 өргөдлийг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай байна.</p>	
Дундаж хувь			100%	

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС  Э. БОЛОРТУЯА

БИЕЛЭЛТ ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА  З. БАЯНДУГАР

